



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/190

Чингис хот

Зорилтот бүлгийн өр хүүдэд нэг удаагийн
тусламж үзүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5, Засгийн газрын 2021 оны 92 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Улаан Загалмайн нийгэмлэгээс санхүүжүүлж байгаа гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зорилтот бүлгийн өрхүүдэд нэг удаагийн хүнсний тусламжийг үзүүлэх ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

М.Өлзийбат

Аймгийн Улаан загалмайн хорооны дарга

Гишүүд:

Б.Бат-Эрдэнэ

Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч

Э.Хонгорзул

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын халамжийн хэлтсийн дарга

В.Цэцэгмаа

Улаан Загалмайн хорооны Гамшгийн менежментийн хөтөлбөрийн ажилтан

2. Хүмүүнлэгийн тусламж авах өрхийг Олсн улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөний үндсэн 7 зарчимд нийцүүлж, ил тод нээлттэй, шударгаар сонгож, зорилтот бүлэгт олгох ажлыг зохион байгуулахыг Улаан загалмайн хорооны дарга /М.Өлзийбат/-д даалгасугай.

3. Бор-Өндөр, Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Хэрлэн сумдад хуваарилагдсан зорилтот бүлгийн өрхийн нэг удаагийн хүнсний тусламжийг халдвар хамгааллын дэглэм, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж татан авах ажлыг дээрх сумдын Засаг дарга нарт даалгасугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжаз/, Шуурхай штабын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011232